

Томас Жеферсон Дунд Сургуулийн сурлагын шударга зарчим

Сурлагын шударга зарчим гэж юу болох, яагаад журам шаардлагатай вэ?

IB Learner Profile¹ –д дурьдсанаар сурагч нь “зарчимч, шударга, анги, хамт олон болон хувь хүний нэр төрийг хүндэтгэх, эрх тэгш зарчмыг тууштай баримталдаг” байх ёстой гэж заасан. Улмаар сурагчид “өөрсдийн хийсэн үйлдэл, түүнээс үүдэж гарах үр дагаврыг бүрэн хариуцах чадвартай” байх ёстой. Жеферсон сургуулийн IB хөтөлбөрийн үндсэн зорилтуудын нэг нь сурагчдын бүтээлч, бие дааж төлөвшихөд урамшуулж, сахилга баттай суралцагч болгож хүмүүжүүлэхэд чиглэнэ. Энэ зорилтыг хангах үүднээс бид сургууль даяар дагаж мөрдөх “Academic Honesty Policy”² -г боловсруулж, үүгээр дагаж мөрдөх журмыг тодорхой болгох, оролцогчдын үүрэг хариуцлага болон журмыг дагаж мөрдөөгүйн улмаас үүдэж гарах үр дагаврыг тодотгох зорилготой юм. Сурагчид заасан дүрэм журмыг ойлгож, сахин биелүүлэх, энэ нь сурлагын амжилт гаргахад чиглэсэн зөв шийдвэр гаргахад нэн ач холбогдолтой гэдгийг ойлгох ёстой.

Сурлагын шударга зарчмын тухай ярих үед ямар ойлголт, үг хэллэгийг мэдвэл зохих вэ?

Authenticity - Бодит ажил: Сурагчийн бүтээсэн бодит ажил гэдэг нь сурагчийн өөрийн, бодож олсон санаанд тулгуурласан, бусдын санаагаар болон үйл ажлаар хүлээн зөвшөөрөгдсөн ажил байх.

Intellectual Property - Оюуны өмч: Оюуны болон бүтээлч сэтгэлгээний төрөлд уран зохиол, зураг урлал зэрэг багтана. Эдгээр нь бүх нийтэд хүлээн зөвшөөрөгдөж хуулиар хамгаалагдсан байх.

Malpractice of misconduct -Сахилга батын зөрчлөөс үүдэх зүй бүс үйлдэл: Бусдад шударга бусаар давуу тал олгоход хүргэж болох ёс бүс үйлдэл.

Зохиогчийн эрх зөрчих талаар өөр мэдвэл зохих зүйлс?- Дараах ойлголт үг хэлцүүдийг анхаарвал зохино :

Хуурч мэхлэх: шалгалт шүүлгийн үеэр нууц тэмдэглэл гэх мэт зөвшөөрөгдөөгүй материал авч ирэх.

Хуулах: Бусад сурагчийн хийсэн ажлыг өөрийнх нь зөвшөөрөлгүй авч, өөрөө хийсэн ажил мэт ашиглах

Зохиогчийн эрх зөрчих: Зохиогч нь тодорхой байгаа хэн нэгний бүтээсэн ажил, үг тэмдэглэл, зураг, мэдээлэл сэлтийг авч ашиглах, улмаар өөрийн ажил мэт хичээлд ашиглах. Зохиогчийн эрх зөрчих үзэгдэл нь хэн нэгний ажлыг ашиглах үед зохиогчийн нэрийг тогтсон журмын дагуу дурьдаагүй үед ихэвчлэн тохиолдоно.

Үгсэн хуйвалдах: Хичээл дээр шударга бүс үйлдэлд бусад сурагчдыг өөгшүүлэн туслах

Зохиогчийн эрх зөрчих, үгсэн хуйвалдах үзэгдэл нь ихэвчлэн санаандгүй гардаг алдаа гэдгийг санах нь чухал юм. Дүрэм журамд тусгагдсан утга санааг болон сурагчид дүрэм журмыг хэрхэн сахиж биелүүлэх арга замуудыг сайн ойлгоогүй тохиолдлууд элбэг тохиолддог. Сурагчид хичээл сурлагад тавих үүрэг хариуцлагаа ухамсарлаж, хичээлийн идэвх чармайлтаа сайжруулах явцад анги хамт олон, эцэг эх, багш нарыг мэдээллийн чухал сурвалж болгох ба энэ үед мэдээллийн эх сурвалжийг орхигдуулах хандлага ажиглагддаг. (Carroll, J., IBMYR 2012)

¹ International Baccalaureate хөтөлбөрт суралцагчийн баримтлах чиглэл. Цаашид “IB Learner Profile” гэж нэрийдэх

² Academic Honesty Policy – Сурлагын шударга зарчим хангах бодлого- цаашид Academic Honesty Policy гэх

Зүй бус үйлдлийн зарим жишээ:

- Гар утас, таблет болон бусад элетрон төхөөрөмжийг зөвшөөрөлгүй ашиглах
- Нууц хуулах материал бэлдэж ирэх
- Шалгалтын асуултыг ёс бусар олж мэдэх
- Багш нарын зөвшөөрөлгүй бусад ангид үзсэн хичээлийг дахин ашиглах
- Бусдын нэрийн өмнөөс дутуу орхисон ажлыг нь хийж гүйцэтгэх (Ангийн ажил г.м)

Сурлагын шударга байдлыг хангахад сургууль дээр хүн бүр хувь нэмэр оруулах ёстой. Эдгээрийн хүлээх үүрэг ямар байх вэ?

Сурагчид сурлагын сахилга зөрчил гаргасан нөхцөлд сургуулийн удирдлага болон зөвлөх багш нар сурагч, эцэг эх, багш нарт дэмжлэг үзүүлэхийн сацуу сахилгын зохих арга хэмжээ авах үүрэгтэй.

Сургуулийн зүгээс:

- Дүрэм журам мөрдүүлэхээс илүүтэй багшлах үр чадварыг сайжруулахад анхаарах
- Их бага бүх зөрчлийг ноцтойд үзэж арга хэмжээ авах (хичээл хуулсан болон дүрэм журам ойлгоогүй тохиолдлуудыг анхааралд авч үзэх)

Сурагчдад сурлагын сахилга батыг ойлгуулах үйл явцад багш нар зааж сургах гол үүрэгтэй ба тэд:

- Сурагчид хичээлд тавигдах дүрэм журмыг ойлгож байгаа эсэхэд анхаарах
- Сурагчдад өгсөн даалгаврыг гүйцэтгэх, улмаар өгөгдсөн ажлыг бүрэн гүйцэтгэх идэвхийг урамшуулахын тулд сурагчийн гаргасан хүсэлт бүрийн мөрөөр үнэлэлт дүгнэлт өгч ажиллах
- Бусдын хийсэн бүтээлийг хүлээн зөвшөөрч хүндлэх зохистой арга замуудыг заах
- Сурагчдад энгийн, тодорхой заавар зөвлөгөө, гарах үр дүнг ойлгуулах
- Бусдын бүтээл ажлыг зүй зохистой ашиглах талаар сурагчид цэгцтэй удирдамж өгөх, босоо тогтолцоот төлөвлөлт (**хичээлийн агуулгаар бүлэглэх**) ашиглах
- Журмын биелэлтийг хянах, үүний утга санааг тайлбарлах, сурагчийн хувийн хэрэгт тэмдэглэх
- Жишээгээр үзүүлэх
- Сурагчдын бие даах чадварт гарч буй аливаа өөрчлөлт бүрийн талаар сурагчдад тодорхой мэдэгдэж байх. Жишээ нь эдгээр өөрчлөлтийн талаар сурагчидтай жишээ авч тайлбарлах буюу харилцан ярилцах замаар мэдэгдэж байх.

Сурагчид:

- Өөрсдөд өгсөн үүрэг даалгаврыг цаг ямагт гүйцэтгэж байх
- Өөрийн хийсэн ажлыг бусдад хуулуулахгүй хамгаалж байх
- Хийж буй ажилд ашиглаж буй материалын эх сурвалжийг олж, онлайн эх сурвалж болон зураг сэлтийн зохиогчийг тодорхой дурьдаж байх
- Ашиглаж буй эх сурвалжийг зохих журмын дагуу дурьдах ба эх сурвалж дурьдах APA болон MLA стандартыг ашиглаж сурах
- Эргэлзээтэй ойлгохгүй зүйл гарвал багш болон номын санчаас дэмжлэг авах
- Гарын үсэг зурж баталгаажуулсан санамжийг дагаж мөрдсөнөөр сурлагын тогтвортой амжилтаа хадгалах

Эх сурвалж дурьдах талаар хаанаас тусламж авч болох вэ?

- Эх сурвалжийн төрлүүд, тэдгээрийн тайлбар болон бусад чухал мэдээллүүдийг “TJMS”-ийн вэбсайтын “IB/Academic Honesty Help” цэснээс үзэж болно

- EasyBib - Жеферсон сургууль EasyBib сайтын захиалгат гишүүн бөгөөд онлайн эх сурвалж дурьдагч үйлчилгээ үзүүлдэг тус вэбсайт нь хэрэглэгчийн ном зүйг санаж хадгалах ба улмаар зохиогчийн эрх зөрчих эрсдлээс хамгаалдаг
- Сургуулийн номын санчаас EasyBib сайтын талаар болоод бусад ном зүй, эх сурвалжтай холбоотой асуултаа тодруулна уу

Сурлагын шударга зарчмыг хангах үүднээс сургуулийн зүгээс ямар алхам хийж болох вэ?

Хичээлийн жилийн явцад томоохон шалгалт шүүлэг юм уу томоохон чухал даалгавар биелүүлэхээс өмнө сурагчид зохиогчийн эрх зөрчихгүй, бусдад хуулуулах юм уу бусдаас хуулахгүй ба бусад зүй бус үйлдэл гаргахгүй гэдгийг бичгээр баталгаажуулж гарын үсэг зурна.



Thomas Jefferson
Лvнл Сvнргvнпъ

Миний бие _____ (сурагч) би Thomas Jefferson
Дунд Сургуулийн Сурлагын шударга зарчим сахих санамжтай
танилцаж ойлгосон болно. Би шударга, хичээлд зарчимч
хандах, журам дүрмийг ямагт хүндэтгэн сахих, хувь хүний
болон өөрийн хамт олны эрх, нэр төрийг хүндэтгэнэ гэдгээ
үүгээр бататгаж байна.

Гарын үсэг: _____
(Сурагч)

Огноо: _____

Миний бие _____ (эцэг/ эх) Thomas Jefferson
Дунд Сургуулийн Сурлагын шударга зарчмыг сахих санамжтай
танилцсан болно.

Би хэрэв ямар нэг зүй бус үйлдэл, зөрчилд холбогдвол ямар арга хэмжээ авах вэ?

Зөрчлийн зэрэг	Тодорхойлолт	Багш, бүлгийн ахлагчаас авах арга хэмжээ	Зөвлөх багш, захирааны зүгээс авах арга хэмжээ
Зэрэг 1	<p>Санамсаргүй зөрчил</p> <p>Туршлагагүйн улмаас зөвхөн анх удаа гаргасан зөрчил. Сурагч өөрийн хийгээгүй ажлыг ирүүлэх, бусдын ажлыг цөөн хэбэлэрээр хуулбарласан.</p> <p><i>Жишээ нь бусдын санааг тусгасан бичвэр бичих юм уу MLA стандартын дагуу зохиогчийг дурьдаагүй байх. Мөн сурагч ангийн хүүхдийн даалгаврыг хуулсан байх, эсвэл тусламж авах нэрийдлээр асуудлыг ойлгохын оронд бэлэн хариулт эрэлхийлэх зэрэг байж болно.</i></p>	<p>Хэрэв даалгавар бол:</p> <ul style="list-style-type: none"> - Сурагчийг оролцуулсан бүлэг хуралдаж цаашид сахилгыг сахиулах талаар зөвлөж мэдэгдэл өгөх - Зөрчлийг бүртгэлд хөтөлж эцэг эхэд мэдээлэх - Багш сурагчдыг даалгаврыг хэрхэн гүйцэтгэх аргыг өөрсдөд нь зөвшөөрч болох ба сурагчид даалгаврын анхны зорилтыг хангахад туслах зорилгоор даалгаврын өгөгдлийг өөрчилж болно. Сурагч бүтэн кредит авч болно. <p>Хэрэв шалгалт бол:</p> <ul style="list-style-type: none"> - Хэрэв сурагч шалгалтын явцад хуулж/ хуулуулж байгаад баригдах, эсвэл шалгалтын дүн сурагч хуулсан/ хуулуулсан нь тодорхой болсон нөхцөлд багш зөрчилд холбогдох сурагчидтай ярилцаж зөрчил болсон эсэх талаар тодруулна. Даалгавар гүйцэтгэхэд гарсан зөрчлийн үед авах алхмууд адил байх ба сурагчид шалгалтыг давтан өгч бүрэн кредит авах боломжтой. 	<p>Зөвлөх багш болон захиргааны зүгээс сурагчид ганцаарчилсан зөвлөх арга хэмжээ шаардлагагүй.</p>
Зэрэг 2	<p>Санаатай зөрчил</p> <p>Сурагч нэг хичээлд юм уу тухайн хичээлийн жилд өөр өөр хичээлүүдэд нэг удаа зөрчил гаргасан байх. ЭСВЭЛ тухайн зөрчил нь илт санаатай үйлдэл байна.</p> <p><i>Эдгээр нөхцлүүдэд сурагч эх сурвалжийг дурьдалгүй бусдын ажлыг бүрэн хуулбарласан, эсвэл бусдын үг хэллэгийг хуулбарласан. Сурагч цахим хэлбэрээр хуулж, зарим гол үг хэлц юм уу бүлэг хэсгийг өөрчилж засварласан байх, эсвэл сурагч шалгалт юм уу даалгаварт санаатай бусдаас хуулсан зэрэг болно.</i></p>	<p>Зэрэг 1-т заасан шалгалт, даалгавартай холбоотой зөрчлийн үед авах арга хэмжээ</p> <p>МӨН</p> <ul style="list-style-type: none"> - Ангийн багш тухайн даалгаврыг болон даалгавартай холбоотой баримтыг хуулбарлаж зөвлөх багшид өгнө <p>МӨН</p> <ul style="list-style-type: none"> - Сурагч сургуулийн хүрээнд сурлагын шударга зарчмын талаар ухуулан сурталчлах даалгавруудаас сонголд хийж гүйцэтгэнэ 	<ol style="list-style-type: none"> 1) Эцэг эх асран хамгаалагчид мэдэгдэн 2) Багш зөрчилтэй холбоотой баримтыг ангийн түвшинд хамаарах зөвлөх багшид хүргүүлнэ 3) Зөвлөх багш сурагчтай уулзаж зөвлөх үйлчилгээ үзүүлнэ 4) Ангийн түвшинд хамаарах дэд захирал юм уу захиралд зөрчлийг мэдээлнэ

<p>Зэрэг 3</p>	<p>Давтан зөрчил Сурагч нэг хичээлд юм үү тухайн хичээлийн жилд өөр өөр хичээлүүдэд давтан зөрчил гаргасан байх.</p> <p><i>Энэ ангилалд сурагч бусдын ажлыг хуулбарлах, эх сурвалжийг зохиож бичих, нэг ажлыг нэгээс дээш удаа ашиглах, шагалтын алдагдсан материал ашиглах, цахим эх сурвалжийг зүй бус ашиглах, хариултыг бусдад хуулуулсан юм үү нийтэд зарлах зэрэг байж болно.</i></p>	<p>Зэрэг 1-т заасан шалгалт, даалгавартай холбоотой зөрчлийн үед авах арга хэмжээ</p> <p>МӨН</p> <ul style="list-style-type: none"> - Ангийн багш тухайн даалгаврыг болон даалгавартай холбоотой баримтыг хуулбарлаж зөвлөх багшид өгнө <p>МӨН</p> <ul style="list-style-type: none"> - Сурагчийг сургууль дээр хичээлээс түдгэлзүүлэх (ISS) арга хэмжээг 1 өдөр авна. 	<p>1-4-д заасан алхмуудыг дагах ба</p> <p>МӨН</p> <ul style="list-style-type: none"> 5) Сурагчийн хувийн хэрэгт зөрчлийн товч мэдээллийг хавсаргана.
-----------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------